



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/144/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах аудитор: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа Утас: 99108763, Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026. 03. 13 № 542
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ё.НЯМЖАВ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Хотын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох, тооллого явуулах” төслийн хүрээнд байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 26 нэр төрлийн 1,500,293.7 мянган төгрөгийн үнэ бүхий 34,275 ширхэг, бэлэн бүтээгдэхүүн дансанд бүртгэлтэй 10-аас дээш жилийн насжилттай, нийт 7 нэр төрлийн 42,817.1 мянган төгрөгийн үнэ бүхий 5,235 ширхэг мод, бут, сөөгийг тоолж, дансны залруулгыг хийж биологийн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Байгууллага нь ашгийн төлөө бус, орон нутгийн төсвөөс 100 хувь санхүүждэг байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүргүүд болох

1426050407

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\wordlywsan bichig\Dugneit 2026.docx

байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл, төсөв, удирдлагын томилгоо, санхүүгийн хяналт, аудит зэргийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга болон холбогдох санхүү, төрийн хяналтын байгууллагууд хэрэгжүүлж байхад Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүнтэй ажиллаж тайлант хугацаанд 47.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 97.8 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	831,292,113.70	2,096,359,073.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,427,587.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	4,427,587.00
3121	Төгрөг	-	4,427,587.00
31211	Төрийн сангийн харилцах	-	4,427,587.00
33	АВЛАГА	101,645,083.30	76,814,425.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	104,042.00	810,677.70
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	56,215,191.30	29,823,237.00
335	Бусад авлага	45,325,850.00	46,180,511.00
3351	Байгууллагаас авах авлага	45,325,850.00	46,180,511.00
35	БАРАА МАТЕРИАЛ	729,647,030.40	2,015,117,061.02
35300	Бэлэн бүтээгдэхүүн	196,577,340.00	1,624,253,340.00
354	Хангамжийн материал	533,069,690.40	390,863,721.02
35410	Бичиг хэргийн материал	697,665.00	218,965.00
35420	Аж ахуйн материал	145,297,773.99	62,164,784.52
35430	Сэлбэг хэрэгсэл	50,059,268.00	51,873,037.36
35440	Түлш, шатах тослох материал	11,140,481.25	18,475,340.75
35470	Бусад хангамжийн материал	325,874,502.16	258,131,593.39
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	212,108,321,690.33	216,090,518,957.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	212,108,321,690.33	216,090,518,957.42
392	Биет хөрөнгө	9,240,588,990.33	11,679,344,043.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,940,765,486.66	3,421,295,239.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,236,091,148.08)	(599,351,395.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	589,200,000.00	1,396,670,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(198,992,083.51)	(297,347,656.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,268,371,938.77	1,045,247,617.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,045,821,996.51)	(507,496,117.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	156,485,903.00	142,488,123.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(91,845,635.44)	(97,075,738.79)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,824,395,360.32	14,307,757,365.17
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,965,878,834.88)	(7,132,843,392.84)
393	Биет бус хөрөнгө	202,867,732,700.00	202,868,064,050.00
39301	Програм хангамж	3,274,600.00	2,987,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,150,000.00)	(531,150.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	202,865,608,100.00	202,865,608,100.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	1,543,110,864.05
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	-	1,543,110,864.05
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	212,939,613,804.03	218,186,878,031.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,838,101.19	7,293,580.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,838,101.19	7,293,580.70
413	Өглөг	2,838,101.19	2,650,001.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	188,100.19	-
4136	Бусад өглөг	2,650,001.00	2,650,001.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,650,001.00	2,650,001.00
414	Урьдчилж орсон орлого	-	4,643,579.70
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	-	215,992.70
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	-	4,427,587.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	212,936,775,702.84	218,179,584,450.44
51	Засгийн газрын хувь оролцоо	212,936,775,702.84	218,179,584,450.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	202,634,096,096.34	202,634,096,096.34
51101	Өмч: - төрийн	202,634,096,096.34	202,634,096,096.34

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	9,944,801,871.95	15,187,610,619.55
51210	Өмнөх үеийн үр дүн	9,944,801,871.95	9,944,801,871.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	5,242,808,747.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	357,877,734.55	357,877,734.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	212,939,613,804.03	218,186,878,031.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,707,099,856.48	14,651,787,847.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,212,411,981.77	9,045,006,042.49
120	Нийтлэг татварын бус орлого	1,212,411,981.77	9,045,006,042.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,212,411,981.77	9,045,006,042.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	759,572,565.00	555,166,519.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,594,457.00	6,528.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	371,570,259.77	6,996,079,994.69
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	42,674,700.00	1,493,753,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,494,687,874.71	5,606,781,804.61
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	121,637,918.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		121,637,918.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,494,687,874.71	5,485,143,886.61
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,494,687,874.71	5,485,143,886.61
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,281,024,302.76	7,940,836,928.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,281,024,302.76	7,940,836,928.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,942,508,780.76	7,788,758,097.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,625,657,134.20	3,829,827,474.45
210101	Үндсэн цалин	1,452,906,376.01	1,906,805,476.57
210102	Нэмэгдэл	468,173,082.55	834,153,922.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	541,140,270.80	953,760,200.00
210104	Урамшуулал	163,437,404.84	135,107,875.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	331,285,166.72	478,155,231.80
210201	Тэтгэврийн даатгал	229,458,808.46	329,832,785.55
210202	Тэтгэмжийн даатгал	28,131,859.86	38,925,122.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,088,406.27	19,505,354.51
210204	Ажилгүйдлийн даатгал	9,400,357.77	17,796,234.04
210205	Эрүүл мэндийн даатгал	51,205,734.36	72,095,735.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,594,367.09	265,823,368.17
210301	Гэрэл, цахилгаан	173,221,567.09	245,597,368.17
210303	Цэвэр, бохир ус	9,890,000.00	10,864,000.00
210304	Байрны түрээс	9,482,800.00	9,362,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	283,169,927.81	581,330,465.04
210401	Бичиг хэрэг	2,236,139.00	1,765,600.00
210402	Тээвэр, шатахуун	45,517,716.00	51,165,140.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,607,829.01	4,574,376.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,901,000.00	7,512,814.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	198,695,679.40	344,128,363.77
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	12,211,564.40	126,858,670.47
210408	Бараа материал акталсны зардал		2,508,400.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		42,817,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	378,013,045.60	96,657,596.64
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	814,600.00	24,478,500.00
210604	Урсгал засвар	377,198,445.60	72,179,096.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	739,787,417.50	818,224,987.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	703,929,369.50	776,446,805.00

**Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	29,080,000.00	28,970,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,353,132.00	5,361,852.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,189,916.00	4,101,330.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	495,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,740,000.00	3,345,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,392,001,721.84	1,718,738,974.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,612,032.40	123,878,618.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	765,000.00	200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,385,624,689.44	1,594,660,356.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	338,515,522.00	152,078,830.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,348,500.00	64,652,236.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		28,955,236.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,348,500.00	35,697,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	321,167,022.00	87,426,594.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,167,022.00	87,426,594.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,573,924,446.28)	6,710,950,918.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,468,142,170.92
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		1,468,142,170.92
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,468,142,170.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,573,924,446.28)	5,242,808,747.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,292,854,896.71	6,192,939,986.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	798,167,022.00	586,158,181.80
120	Нийтлэг татварын бус орлого	798,167,022.00	586,158,181.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	798,167,022.00	586,158,181.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	798,167,022.00	586,151,653.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,528.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,494,687,874.71	5,606,781,804.61
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	121,637,918.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		121,637,918.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,494,687,874.71	5,485,143,886.61
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,494,687,874.71	5,485,143,886.61
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,067,211,963.71	6,139,592,599.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,067,211,963.71	6,139,592,599.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,727,307,041.71	5,984,943,768.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,625,960,305.18	3,830,723,036.15
210101	Үндсэн цалин	1,371,716,682.66	1,915,797,877.94
210102	Нэмэгдэл	534,103,565.93	833,150,354.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	540,706,530.09	947,756,541.36
210104	Урамшуулал	179,433,526.50	134,018,262.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	329,064,863.03	478,958,666.99
210201	Тэтгэврийн даатгал	227,021,091.11	330,301,894.77
210202	Тэтгэмжийн даатгал	26,361,611.86	39,298,953.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,398,859.16	19,498,220.21
210204	Ажилгүйдлийн даатгал	7,175,042.75	17,792,399.74
210205	Эрүүл мэндийн даатгал	54,108,258.15	72,067,198.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,594,367.09	272,009,368.17
210301	Гэрэл, цахилгаан	171,469,567.09	245,597,368.17
210303	Цэвэр, бохир ус	11,642,000.00	17,050,000.00
210304	Байрны түрээс	9,482,800.00	9,362,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	117,764,450.01	94,168,636.30
210401	Бичиг хэрэг	2,524,438.00	1,305,050.00
210402	Тээвэр, шатахуун	52,128,676.00	56,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,882,829.01	4,574,376.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,982,000.00	7,512,814.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	424,441,954.00	121,514,906.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,793,900.00	12,613,650.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	30,680,600.00	38,990,000.00
210604	Урсгал засвар	388,967,454.00	69,911,256.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,025,810,696.00	1,067,790,537.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	989,952,648.00	1,031,197,355.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	29,080,000.00	21,985,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,353,132.00	5,361,852.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,189,916.00	4,101,330.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	495,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,740,000.00	5,145,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,670,406.40	119,778,618.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,905,406.40	119,578,618.00

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	765,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	339,904,922.00	154,648,830.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,737,900.00	67,222,236.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		28,955,236.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,737,900.00	38,267,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	321,167,022.00	87,426,594.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,167,022.00	87,426,594.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	225,642,933.00	53,347,387.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	225,642,933.00	48,919,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	225,642,933.00	48,919,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	225,642,933.00	48,919,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	225,642,933.00	48,919,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(225,642,933.00)	(48,919,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	4,427,587.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,427,587.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,634,096,096.34	357,877,734.55	11,473,400,468.23	214,465,374,299.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	45,325,850.00	45,325,850.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	202,634,096,096.34	357,877,734.55	11,518,726,318.23	214,510,700,149.12
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,634,096,096.34	357,877,734.55	11,518,726,318.23	214,510,700,149.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	202,634,096,096.34	357,877,734.55	11,518,726,318.23	214,510,700,149.12
Тайлант үеийн үр дүн	-	-	5,242,808,747.60	5,242,808,747.60
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,634,096,096.34	357,877,734.55	16,761,535,065.83	219,753,508,896.72

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,852,323,800.00	5,979,447,886.61	872,875,913.39	87.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,358,019,800.00	5,397,717,291.81	960,302,508.19	84.9
132001	Орон нутгийн төсвөөс	6,358,019,800.00	5,397,717,291.81	960,302,508.19	84.9
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	494,304,000.00	581,730,594.80	(87,426,594.80)	117.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	494,304,000.00	581,730,594.80	(87,426,594.80)	117.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР З ЭЭЛИЙН ДҮН	6,852,323,800.00	5,979,447,886.61	872,875,913.39	87.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,852,323,800.00	5,979,447,886.61	872,875,913.39	87.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,771,567,300.00	5,912,225,650.61	859,341,649.39	87.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,267,036,300.00	3,830,723,036.15	436,313,263.85	89.8
210101	Үндсэн цалин	2,043,973,500.00	1,915,797,877.94	128,175,622.06	93.7
210102	Нэмэгдэл	1,035,986,800.00	833,150,354.85	202,836,445.15	80.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,168,860,000.00	947,756,541.36	221,103,458.64	81.1
210104	Урамшуулал	18,216,000.00	134,018,262.00	(115,802,262.00)	735.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	536,879,600.00	478,958,666.99	57,920,933.01	89.2
210201	Тэтгэврийн даатгал	365,078,100.00	330,301,894.77	34,776,205.23	90.5
210202	Тэтгэмжийн даатгал	42,950,400.00	39,298,953.90	3,651,446.10	91.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,475,200.00	19,498,220.21	1,976,979.79	90.8
210204	Ажилгүйдлийн даатгал	21,475,200.00	17,792,399.74	3,682,800.26	82.9
210205	Эрүүл мэндийн даатгал	85,900,700.00	72,067,198.37	13,833,501.63	83.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	315,435,200.00	269,950,068.17	45,485,131.83	85.6
210301	Гэрэл, цахилгаан	287,352,400.00	243,538,068.17	43,814,331.83	84.8
210303	Цэвэр, бохир ус	18,600,000.00	17,050,000.00	1,550,000.00	91.7
210304	Байрны түрээс	9,482,800.00	9,362,000.00	120,800.00	98.7
2104	Хангамж, бараа материалын зардал	131,747,200.00	94,168,636.30	37,578,563.70	71.5
210401	Бичиг хэрэг	1,757,500.00	1,305,050.00	452,450.00	74.3
210402	Тээвэр, шатахуун	68,381,700.00	56,000,000.00	12,381,700.00	81.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,080,000.00	4,574,376.30	1,505,623.70	75.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	28,800,000.00	7,512,814.00	21,287,186.00	26.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,728,000.00	24,776,396.00	1,951,604.00	92.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	203,260,000.00	150,662,706.00	52,597,294.00	74.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,095,000.00	41,761,450.00	5,333,550.00	88.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	42,220,000.00	38,990,000.00	3,230,000.00	92.3
210604	Урсгал засвар	113,945,000.00	69,911,256.00	44,033,744.00	61.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,316,409,000.00	1,087,562,537.00	228,846,463.00	82.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,270,470,000.00	1,050,969,355.00	219,500,645.00	82.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	25,105,000.00	21,985,000.00	3,120,000.00	87.6
210803	Даатгалын үйлчилгээ	6,602,000.00	5,361,852.00	1,240,148.00	81.2

**Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,713,200.00	4,101,330.00	611,870.00	87.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,373,800.00	-	4,373,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,145,000.00	5,145,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	200,000.00	600,000.00	25.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	200,000.00	600,000.00	25.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,756,500.00	67,222,236.00	13,534,264.00	83.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,756,500.00	67,222,236.00	13,534,264.00	83.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,955,500.00	28,955,236.00	264.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,801,000.00	38,267,000.00	13,534,000.00	73.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	139	125	1	89.9
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	121	107	14	88.4

2.6 Аудит хийсэн Нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	121,637,918.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	121,637,918.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	121,637,918.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	121,637,918.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	121,637,918.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	121,637,918.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	2,059,300.00
210301	Гэрэл, цахилгаан	-	2,059,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	95,018.00
210402	Тээвэр, шатахуун	-	95,018.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,000,000.00
210604	Урсгал засвар	-	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	117,483,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	117,483,600.00

Илрүүлэлт: Байгууллага нь ашгийн төлөө бус, орон нутгийн төсвөөс 100 хувь санхүүждэг байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүргүүд болох байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл, төсөв, удирдлагын томилгоо, санхүүгийн хяналт, аудит зэргийг НИТХ, НЗД болон холбогдох санхүү, төрийн хяналтын байгууллагууд хэрэгжүүлж байхад ТУЗ-ийн 5 гишүүнтэй ажиллаж тайлант хугацаанд 47,500.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь: Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д *“Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”,* 76.1.1-д *“компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох”,* 76.1.8-д *“компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох”,* 76.1.13-д *“төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Удирдлагын чиг үүргийн давхардлыг арилгах, шийдвэр гаргалтыг оновчтой болгох, төсвийн сахилга бат, үр ашигтай байдлыг хангах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад хөрөнгө тоолсон тухай илтгэх хуудас, тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т *“комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”,* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *“холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн тооллогын илтгэх хуудас бичиж хэвших, тооцоог бодож, хөрөнгийн дансны үлдэгдэлтэй тулган шалгаж байх.

Илрүүлэлт: Сэлбэг хэрэгслийн материалын 46,622.6 мянган төгрөгийн зарлага хийхдээ өмч хамгаалах байнгын зөвлөл, техникийн комиссын актыг үндэслээгүй бөгөөд сэлбэг хэрэгслийг сольсон, засварласан талаар нотлох баримт, зарцуулалтын тайлангүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”,* 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,* 20 дугаар зүйлийн 20.1.4-т *“хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сэлбэг хэрэгслийн зарлагыг зөвшөөрөгдсөн журмын дагуу зөвхөн өмч хамгаалах байнгын зөвлөл, техникийн комиссын актад үндэслэн гүйцэтгэж, сольж засварласан бүртгэл, нотлох баримт, зарцуулалтын тайланг бүрэн бүрдүүлж ажиллах.

Илрүүлэлт: Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т *“Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах”*

үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-т "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тодруулга тайланг бэлтгэж байх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сэлбэг хэрэгслийн материалын зарлага техникийн комиссын актгүй сольсон, зарцуулалтын тайлан огт байхгүй байна.	1	-					1	46,622.6				
Үндсэн хөрөнгийн тооллогын баримтын бүрдэл дутуу	1	-					1	-				
Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-					1	-				
Дүн	3	46,622.6					3	46,622.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүнтэй ажиллаж тайлант хугацаанд 47,500.0 мянган төгрөгийн зардал гаргасан	1	47,500.0					1	47,500.0
Дүн	1	47,500.0	-	-			1	47,500.0